



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 3 сарын 12 өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

Хяналт шалгалтын мөрөөр  
авах арга хэмжээний тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.4 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.5.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аудитын байгууллагад тавигдах нөхцөл шаардлагыг хангаж ажиллаагүй “Ол дөш хайрхан Аудит” ХХК, “Ворлдгал Аудит” ХХК, “Гэрэлт хөхийн тэнцвэр Аудит” ХХК, “Төгс нягт гурав Аудит” ХХК, “Сан арвигч Аудит” ХХК болон “Бурхил Аудит” ХХК-дын аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 3 сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

Хоёр. Дор дурьдсан арга хэмжээ авч ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Г.Түвдэндорж/-т үүрэг болгосугай.

2.1/ зөрчил гаргасан аудитын байгууллагад хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч, хяналт тавьж ажиллах,

2.2/ Монголын мэргэшсэн нягтлан бодогчдийн институтийн Ёс зүйн хороонд нэр бүхий мэргэшсэн нягтлан бодогч аудиторүүдэд арга хэмжээ авч ажиллах үүрэг даалгавар өгч, хяналт тавьж ажиллах,

2.3/ хяналт шалгалтанд хамрагдаагүй аудитын байгууллагыг төлөвлөгөөт хяналт шалгалтанд хамруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах,

Гурав. Энэ тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Г.Түвдэндорж/-т даалгасугай.

САЙД



Ч.ХҮРЭЛБААТАР